



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 09 дүгээр сарын 25
№36 (1431)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------------------|------|
| 348. | Б.Баттулгын нэхэмжлэлтэй, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд тус тус холбогдох захиргааны хэргийн тухай | Дугаар 001/ХТ2026/0031 | 2827 |
| 349. | “Ти Ар Эс Жи” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны улсын байцаагчид холбогдох захиргааны хэргийн тухай | Дугаар 001/ХТ2026/0036 | 2840 |

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар: 001/ХТ2026/0031

Улаанбаатар
хот

**Б.Баттулгын нэхэмжлэлтэй, Дархан-Уул
аймгийн Шарын гол сумын Засаг дарга, Дархан-Уул
аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн
Нийтийн Хуралд тус тус холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:
Шүүгчид:

Д.Батбаатар
М.Батсуурь
П.Соёл-Эрдэнэ
Ц.Цогт
Г.Банзрагч
Б.Зэнээмэдрээ

Илтгэгч шүүгч:
Нарийн бичгийн дарга:

Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 114/ШШ2025/0046 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны
01 дүгээр сарын 07-ны өдрийн 221/МА2026/0026 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид: Нэхэмжлэгч Б.Баттулга, хариуцагч
Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын итгэмжлэгдсэн
төлөөлөгч Э.Дамдиндорж, хариуцагч Дархан-Уул аймгийн Шарын гол
сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгч М.Серкболд,
гуравдагч этгээд Г.Мөнхжаргал, түүний өмгөөлөгч Ж.Ундармаа нарыг
оролцуулж,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 001/ШХТ2026/0090
дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.4-т заасан
үндэслэл байгаа эсэхийг гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан
гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага:



Б.Баттулга нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд тус тус холбогдуулан “Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/10, Б/11 дүгээр захирамжийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

2. Хэргийн нөхцөл байдал:

2.1. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолоор багийн Засаг даргад нэр дэвшигч Г.Мөнхжаргал нь 109 санал буюу 50,5 хувийн санал авсан тул тухайн багийн Засаг даргаар томилуулахаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргад уламжлахаар шийдвэрлэсэн.

2.2. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “... Г.Мөнхжаргалыг Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн Засаг даргаар томилохоос татгалзаж, багийн иргэдийн Нийтийн Хурлыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллана уу” гэсэн 01/205 дугаар албан бичгийг тус сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд хүргүүлсэн. Үүний хариуд багийн иргэдийн Нийтийн Хурлаас “... хуралд оролцсон иргэдээс гомдол, санал гаргаагүй бөгөөд хуулийн хүрээнд зохион байгуулагдсан тул иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг дахин зохион байгуулах үндэслэлгүй” гэсэн албан бичгийг Засаг даргад хүргүүлсэн байна.

2.3. Улмаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/10 дугаар захирамжаар Б.Баттулгыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/11 дүгээр захирамжаар Г.Мөнхжаргалыг Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн Засаг даргаар томилжээ.

3. Нэхэмжлэгчээс дараах үндэслэлээр маргаж байна. Үүнд:

“... Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасныг зөрчиж Хайрхан багийн иргэн Г.Мөнхжаргал нь Дархан багийн Засаг даргын сонгуульд нэр дэвшиж, Санжинт багийн иргэн М.Серкболд, Шарын гол сумын иргэн биш П.Адъяа нар уг багийн Засаг даргыг сонгох сонгуулийн

санал хураалтад оролцож санал өгсөн. Мөн сонгуулийн санал өгөх нэрсийн бүртгэл хаагдсаны дараа нэмж 3 иргэн санал хураалтад оролцож таслах эрх эдэлсэн нь дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.5.2-т заасныг давхар зөрчсөн. Эдгээр нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн. Засаг даргаас Г.Мөнхжаргалыг томилохоос татгалзсан тул хуульд заасны дагуу дахиж сонгууль явагдана гэсэн ойлголттой, бас хүлээлттэй байсан. Гэтэл намайг хууль бусаар үүрэгт ажлаас чөлөөлж, Хайрхан багийн иргэн Г.Мөнхжаргалыг Дархан багийн Засаг даргаар томилсонд гомдолтой. Хуульд байхгүй үндэслэл шалтгаанаар дахин нэр дэвшүүлэх үүргээ багийн иргэдийн Нийтийн Хурал биелүүлээгүй тул тус Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан илт хууль бус акт гэж үзэх үндэслэлтэй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү” гэжээ.

4.Хариуцагч Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга тайлбартаа “... Дархан багийн Засаг даргыг сонгох санал хураалтад Б.Баттулга 107, Г.Мөнхжаргал 109 хүний санал авсан ба Дархан багийн Засаг даргыг сонгох санал өгөх нэрсийн жагсаалтад Санжинт багийн иргэн М.Серкболд, Шарын гол сумын иргэн биш П.Адъяа нар нь санал өгсөн. Мөн тухайн хуралд оролцохоор ирсэн иргэдийг хурлын ирц хаагдсан гэх шалтгаанаар оролцуулаагүй атлаа ирц хаагдсаны дараа нэр бүхий 3 иргэнийг хуралд оролцуулан санал өгүүлж тухайн багийн Засаг даргын сонгууль хууль бус болсон нь анхан шатны бүртгэл бусад баримтаар нотлогдсон тул Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.7-д заасныг үндэслэн Г.Мөнхжаргалыг томилохоос татгалзсан. Хуралд оролцсон иргэдийн эрх ашиг, нийт Дархан багийн иргэдийн сонгох, сонгогдох эрх ашиг хөндөгдөж байх тул нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй ... Маргаан бүхий иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоолыг илт хууль бус шийдвэр гэж үзэж байна” гэжээ.

5.Хариуцагч Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурал нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй” гэсэн болохоос зөвхөн багийн иргэд оролцоно гэж заагаагүй. ... Хэрэв бүртгэлгүй хүн байсан бол тухайн албан хаагчид бүртгэхгүй. Иргэдээс өргөдөл, гомдол ирээгүй. Тооллогын комиссын шийдвэр болон хуульд нийцүүлэн тус Хурлыг зохион байгуулсан тул хуралдааныг дахин зохион байгуулах үндэслэлгүй. Б.Баттулга тухайн комиссын шийдвэр болон хурлын шийдвэртэй санал нийлэхгүй татгалзах саналтай байсан бол тухайн хурал дээр саналаа хэлж болох байсан. Мөн гомдлоо цаасан хэлбэрээр өгөх хангалттай хугацаа



байсан боловч өгөөгүй. Сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн гэсэнтэй санал нийлэхгүй ...” гэжээ.

6. Гуравдагч этгээд Г.Мөнхжаргал нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “...

Миний бие Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгчөөр 3 удаа сонгогдсон иргэдийн төлөөлөл юм. Тэр утгаараа сонгох, сонгогдох эрхээ эдэлж багийн Засаг даргын сонгуульд нэр дэвшин өрсөлдсөн. Хуульд өөр багийн иргэн нэр дэвшиж болохгүй гэсэн заалт байхгүй. Би хуралд саналын эрхгүй оролцсон. Нэхэмжлэгчийн гомдолд нэр дурдсан таван хүн нь аль багийн иргэн, аль намын гишүүн гэдгийг би мэдэхгүй. Санал хураалт нууцаар явагдсан учир тэр хүмүүс хэнд санал өгснийг хэн ч мэдэх боломжгүй. Тэдгээр хүмүүсийг надтай холбож санал өгсөн мэтээр тайлбарлаж буй нь үндэслэлгүй. Намайг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.9-т заасныг зөрчин 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр томилсон. Саналын дүнг үндэслэж гарсан маргаан бүхий иргэдийн Нийтийн Хурлын тогтоол үндэслэлтэй. Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

7. Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 114/ШШ2025/0046 дугаар шийдвэрээр “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.5, 32.5.2, 56 дугаар зүйлийн 56.2, 56.4, 56.5, 56.7, 56.8, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг ханган, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолыг илт хууль бус болохыг тогтоож, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/11 дүгээр захирамжийг хүчингүй болгож, үлдэх Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/10 дугаар захирамжийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

7.1. “... нэхэмжлэгч болон гуравдагч этгээд нарын хувьд 2 хүний саналын зөрүүгээр Г.Мөнхжаргал олонхын санал авсанд тооцогдсон, ... тухайн багийн иргэн биш М.Серкболд, П.Адъяа нарын хувьд хэнд нь санал өгсөн гэдгийг шүүхийн зүгээс мэдэх болон тогтоох боломжгүй тул үүнийг багийн Засаг даргыг сонгох сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн гэж үзэхээр байна.

7.2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1, 56.5.2-т зааснаар багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч багийн Засаг даргад тавигдах шаардлагыг хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэх санал гаргах эрхтэй ба тухайн хүн олонхын санал авсан бол багийн иргэдийн Нийтийн Хурал тухайн багийн Засаг даргаар томилуулахаар нэр дэвшүүлэхээр зохицуулсан болохоос багийн Засаг дарга нь заавал тухайн багийн сонгуулийн эрх бүхий иргэн байхыг шаардаагүй, түүнчлэн, хуулийн үзэл баримтлалд энэ талаар нарийвчлан тусгаагүй, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.5.2, 64 дүгээр зүйлд заасныг системчлэн тайлбарлавал, багийн иргэдийн Нийтийн Хуралд тухайн багийн сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй, ийнхүү оролцсон тохиолдолд асуудал шийдвэрлэхэд таслах эрх эдлэх талаар зохицуулсан болохоос багийн иргэн биш сонгуулийн эрх бүхий иргэн оролцох эрхгүй гэж хуульчлаагүй төдийгүй Засаг даргыг чөлөөлөх, огцруулах, огцрох үндэслэлд энэ талаар зохицуулаагүй тул багийн Засаг даргад тухайн багийн иргэн байх хуулийн шаардлага тавигдаагүй гэж үзлээ.

7.3.Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэн В.Дайриймаа, А.Сайнзаяа, Ч.Болорцэцэг нар тухайн багийн 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн иргэдийн Нийтийн Хуралд оролцохдоо хуралдаан эхэлснээс хойш санал хураалт явагдахаас өмнө бүртгүүлэн оролцож санал өгсөн болох нь тэдгээрийн өөрсдийн өгсөн гэрчийн мэдүүлэг, ирчийн бүртгэлээр тогтоогдсон. Иймд багийн иргэдийн Нийтийн Хуралд асуудал шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох эрхийг тухайн Хурлын оролцогч буюу багийн сонгуулийн эрх бүхий иргэн эдлэхээр хуульд тодорхой заасан байхад үүнийг зөрчиж өөр багийн хүмүүс оролцуулж, уг эрхийг эдэлсний улмаас багийн Засаг даргыг сонгох сонгуулийн үр дүнд нөлөөлсөн нь нэхэмжлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тул Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолыг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэх нь зүйтэй.

7.4.Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны Б/10 дугаар захирамж нь тус сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоолыг үндэслэсэн, уг тогтоол нь илт хууль бус боловч нэхэмжлэгчийн маргаж буй албан тушаал нь төрийн улс төрийн албан тушаалд хамаарах төдийгүй тодорхой хугацаанд эрхэлдэг, тухайн үед Дархан багийн Засаг даргын сонгууль болсон, нэхэмжлэгчийн хувьд түр томилогдсон тул маргаан бүхий 2025 оны Б/10 дугаар захирамжийн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж шүүх



үзэхээргүй байх тул дээрх захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэлээ.

7.5.Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоол нь илт хууль бус ба хуульд зааснаар гарсан цагаасаа эхлэн эрх зүйн үйлчлэлгүй тул түүнийг үндэслэн гарсан хариуцагчийн 2025 оны Б/11 дүгээр захирамж хууль бус юм. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга нэхэмжлэгчээс гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзээд Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоолоор багийн Засаг даргаар Г.Мөнхжаргалыг томилуулахаар нэр дэвшүүлснийг хүлээн аваад томилохоос татгалзсан атлаа дахин хуульд заасан журмын дагуу нэр дэвшүүлэх ажиллагааг хийгээгүй байхад маргаж буй 2025 оны Б/11 дүгээр захирамжийг гаргасан нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д нийцэхгүй, иймд хүчингүй болгох үндэслэлтэй ..." гэх зэргээр дүгнэжээ.

8.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 221/МА2026/0026 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

9.Гуравдагч этгээд Г.Мөнхжаргал хяналтын журмаар гаргасан гомдолдоо: "...

9.1.Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий гараагүй тухайд: Анхан шатны шүүх Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5, 47.1.6-д зааснаар "илт хууль бус" гэж дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй. Дээрх тогтоол нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8.4, багийн иргэдийн Нийтийн Хурлын анхдугаар хуралдаанаас байгуулагдсан тооллогын комиссын шийдвэрүүд, хуралдааны даргыг сонгосон 02 дугаар тогтоолыг тус тус хууль ёсоор үндэслэн гарсан бөгөөд уг тогтоол нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8.3-т заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргыг сонгосон, хуульд нийцсэн хүчин төгөлдөр акт юм.

9.2.Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд нийт 232 иргэн оролцсоноос 216 саналын хуудас бөглөгдөж, 100 хувь хүчинтэйд тооцогдсон бөгөөд Б.Баттулга 107 санал (49.5%), Г.Мөнхжаргал 109 санал (50.5%) авсан нь санал тооллогын дүнгээр тогтоогдсон. Шүүх "өөр багийн иргэд санал өгсөн байж болзошгүй" гэх таамаглалд тулгуурлан, нууц санал

хураалтын үр дүнг үгүйсгэсэн нь нотлох баримтыг бодитой үнэлээгүй, таамаглалд суурилсан дүгнэлт гаргасан ноцтой алдаа юм. Сонгуулийн нууцын зарчмын улмаас аль иргэн хэнд санал өгснийг тогтоох хууль зүйн боломжгүй байхад гуравдагч этгээд Г.Мөнхжаргалд санал өгсөн байж болзошгүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй.

9.3.Хоорондоо уялдаа бүхий захиргааны актуудын талаарх шүүхийн дүгнэлт логикийн зөрчилтэй тухайд: Анхан шатны шүүх Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/10 дугаар захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон атлаа, тус захирамжийн хууль зүйн үндэслэл болсон 2025 оны 03 дугаар тогтоолыг илт хууль бус хэмээн хүчингүй болгосон. Маргаан бүхий дээрх захирамж нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоолыг үндэслэсэн. Үндэслэсэн акт нь хүчингүй болсон нөхцөлд түүнээс улбаатай захирамжийг хууль ёсны гэж үзсэн нь шүүхийн шийдвэр логик, эрх зүйн хувьд зөрчилтэй байна. Энэ нь “шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” зарчмыг ноцтой зөрчсөн.

9.4.Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд халдсан тухайд: Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 62 дугаар зүйлийн 62.1, 62.2-т заасны дагуу багийн Засаг даргыг нэр дэвшүүлэх нь тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлын онцгой бүрэн эрх юм. Дархан багийн иргэдийн Нийтийн Хурал хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд, шууд ардчиллын зарчмаар хуралдаж, санал хураан шийдвэр гаргасан байхад шүүх уг бүрэн эрхэд хөндлөнгөөс халдаж хүчингүй болгосон нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй. Иймд шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

10.Нэхэмжлэгч болон хариуцагч Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс “гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлгүй тул шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж өгнө үү” гэсэн агуулгатай тайлбар өгсөн, хариуцагч иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгч тайлбар өгөөгүй болно.

11.Хяналтын шатны шүүх гуравдагч этгээдийн гомдлыг “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” үндэслэл байгаа эсэхийг хянан хэлэлцэхээр хүлээн авсан болно.



ХЯНАВАЛ:

12.Гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах үндэслэлгүй.

13. Хэргийн үйл баримтын тухайд:

13.1.2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд 232 иргэн оролцсоноос 216 хүн саналын хуудас бөглөсөн, үүнээс хүчинтэй 216 (100 хувь), нэхэмжлэгч Б.Баттулгад 107 (49.5%) санал, гуравдагч этгээд Г.Мөнхжаргалд 109 (50.5%) санал өгсөн тул тухайн өдрийн Хурлын 03 дугаар тогтоолоор гуравдагч этгээд Г.Мөнхжаргалыг Дархан багийн Засаг даргаар томилуулахаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргад уламжлахаар шийдвэрлэжээ.

13.2.Энэхүү Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд тухайн багийн оршин суугч биш Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 3 дугаар багийн Санжинт ойн 2 гудамж, 8 тоот хаягт бүртгэлтэй М.Серкболд, Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багийн 6 хорооллын 24 дүгээр байрны 86 тоот хаягт бүртгэлтэй П.Адъяа нар оролцож, Засаг даргыг сонгох сонгуульд санал өгсөн болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон.

13.3.Засаг даргад нэр дэвшигч Г.Мөнхжаргал нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Хайрхан багийн оршин суугчийн бүртгэлтэй, уг үйл баримттай талууд маргаагүй болно.

14.Энэ хэргийн тухайд, хяналтын шатны шүүхээс “Засаг даргад нэр дэвшигч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид бүртгэлтэй оршин суугч иргэн байх шаардлагатай эсэх”-ийг тайлбарлах нь хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзлээ.

15.Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1-д зааснаар “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, иймээс Тавин долдугаар зүйлийн 1-ийн дагуу “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, эдгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх удирдлага нь мөн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1-д зааснаар “нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ”.

16.Үндсэн хуулиар баталгаажуулсан “төрийн байгууламжийн нэгдмэл байх зарчим”-ын хэрэгжилтийг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцохтой холбогдох үүссэн харилцааг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулдаг.

17.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Баг нь нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх анхан шатны нэгж мөн”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Багийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:”, 23.1.1-д “нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хуульд заасны дагуу хүргэх үйлчилгээ; ...” гэх зэргээр заасан байх бөгөөд энэхүү анхан шатны нэгжийн удирдлага нь “нутгийн өөрөө удирдах байгууллага” болох багийн иргэдийн шууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурал болон орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч Засаг даргаас бүрдэнэ.

18.Нутгийн өөрөө удирдлагыг хэрэгжүүлэх арга, хэлбэрийг дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй”, 32.4-т “Иргэн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд биеэр хүрэлцэн ирснээр баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын оролцогч болно”, 32.5-т “Иргэдийн Нийтийн Хурлын оролцогч дараах эрх, үүрэгтэй байна:” гээд, 32.5.2-т “асуудал шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох” гэж тус тус заасан байна.

19.Дээрх хуулийн агуулгаас үзвэл, баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд (цаашид Хурал гэх) тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэд биеэр хүрэлцэн ирж, таслах эрхтэй оролцохоор хуульчилсан, гэтэл энэ хэргийн тухайд, 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр болсон Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн иргэдийн Нийтийн Хуралд өөр багийн оршин суугч иргэд болох М.Серкболд, П.Адъяа нар оролцож, тус багийн Засаг даргыг сонгоход санал өгсөн нь хууль зөрчсөн, энэ нь сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн талаарх анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй.

20.Тодруулбал, Дархан багийн Засаг даргыг сонгох тухайн өдрийн Хуралд нэр дэвшигч нэхэмжлэгч Б.Баттулга 107 санал, гуравдагч этгээд Г.Мөнхжаргал 109 санал авч, 2 саналын зөрүүгээр ялагч болсон, энэхүү сонгуулийн үр дүнд санал өгөх эрхгүй 2 иргэний санал нөлөөлөх боломжтой байх тул “сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн” гэж үзнэ.



21. Ийнхүү Хуралд оролцох эрхгүй иргэд оролцож, сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн байхад хариуцагч Дархан багийн иргэдийн Нийтийн Хурлаас 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолоор нэр дэвшигч Г.Мөнхжаргалыг багийн Засаг даргаар томилуулахаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргад уламжлахаар шийдвэрлэсэн нь “илт хууль бус”, энэ талаарх шүүхүүдийн дүгнэлт зөв байна.

22. Тодруулбал, багийн иргэдийн Нийтийн хуралд оролцох эрхгүй иргэд оролцож, сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлсөн нь хуулиар баталгаажуулсан “нутгийн өөрөө удирдах ёс”-ны зарчим буюу тухайн орон нутгийн иргэд өөрсдийн удирдлагыг сонгох эрхийг нь зөрчсөн, энэ тохиолдолд хариуцагч Хурлаас маргаан бүхий тогтоолыг гаргах ёсгүй буюу Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д зааснаар “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” байхад гуравдагч этгээдийг Засаг даргаар томилуулахаар дээд шатны Засаг даргад уламжилсан нь илт хууль бус алдаанд тооцогдоно.

23. Мөн хариуцагч Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга дээрх Хурлын илт хууль бус тогтоолыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/11 дүгээр захирамжаар гуравдагч этгээд Г.Мөнхжаргалыг Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн Засаг даргаар томилсон нь хууль бус тул уг актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр үндэслэлтэй.

24. Иймээс “... Хурлын тогтоол нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8.4, тооллогын комиссын шийдвэрүүдийг үндэслэн гарсан, хуульд нийцсэн хүчин төгөлдөр акт байхад шүүх илт хууль бус гэж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, ... шүүх “өөр багийн иргэд санал өгсөн байж болзошгүй” гэх таамаглалд тулгуурлан, нууц санал хураалтын үр дүнг үгүйсгэсэн нь нотлох баримтыг бодитой үнэлээгүй, таамаглалд суурилсан дүгнэлт гаргасан нь ноцтой алдаа юм, ... шүүх иргэдийн Нийтийн Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан ...” гэсэн агуулгатай гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг (Тодорхойлох хэсгийн 9.1-9.2, 9.4-т) хангах боломжгүй.

25. Хоёр шатны шүүхийн шийдэл зөв боловч “... багийн Засаг даргад нэр дэвшигч хуульд зааснаар бүрэн дундаас дээш боловсролтой, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, ялгүй байх гэсэн үндсэн 4 шаардлагыг хангах ёстой, харин заавал тухайн багийн сонгуулийн эрх бүхий иргэн байхыг хуулиар шаардаагүй байна ...” гэх дүгнэлт буруу, хуулийн зорилгод нийцээгүй байна.

26. Учир нь, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж, 58 дугаар зүйлийн 58.1-д багийн Засаг даргын бүрэн эрхийг хуульчлахдаа “багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх; сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах; асрамж, халамж шаардлагатай иргэнийг асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах; нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн халамж, үйлчилгээг зохион байгуулах; гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ...” гэх зэргээр заажээ.

27. Дээрх хуулийн зохицуулалтаас үзвэл, хэдийгээр нутгийн өөрөө удирдах байгууллага гэж бүх шатны Хурлыг тухайлан заасан боловч Үндсэн хуулийн үзэл санаа ёсоор Засаг дарга Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцоходоо тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч болохыг уг хуулиар баталгаажуулсан, мөн орон нутаг дахь төрийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьд харьяалах нутаг дэвсгэрийн иргэдэд өдөр тутамд төрийн үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй байна.

28. Үүний тулд Засаг дарга өөрийн орон нутаг, иргэд, тэдэнд тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замыг бусдаас илүү мэддэг, орон нутгийнхаа иргэдийн итгэлийг хүлээсэн, тэднийг төлөөлөх чадвартай, Хурлын шийдвэр болон төрийн үйлчилгээг өдөр тутамд хэрэгжүүлэх боломжтой байхын тулд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн (энэ тохиолдолд тухайн багийн) оршин суугч байх зайлшгүй шаардлагатай юм.

29. Ийм ч учир хууль тогтоогчоос орон нутгийн анхан шатны нэгжүүдэд, тухайлбал багт Засаг даргад нэр дэвшигчийн болзол хангах хүн хангалттай байдаггүй бодит нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн (Шинэчилсэн найруулга) 56 дугаар зүйлийн 56.4.1 дэх хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар “хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой” иргэн нэр дэвшиж болохоор өөрчилсөн байдаг.



30.Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, хэдийгээр хуульд Засаг даргад нэр дэвшигч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугч (тухайлбал, багийн) сонгуулийн эрх бүхий иргэн байхыг тухайлан заагаагүй ч, холбогдох хуулийн агуулга, зорилгоос үзвэл, “Засаг дарга (нэр дэвшигч) нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суух иргэн байна” гэж тайлбарлахаар байна. Энэ агуулгаар хоёр шатны шүүхийн дүгнэлтийг залруулах нь зүйтэй.

31.“... Хариуцагч Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/10 дугаар захирамж нь (нэхэмжлэгчийг Засаг даргын түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлсөн) Дархан багийн иргэдийн нийтийн Хурлын 2025 оны 03 дугаар тогтоолыг үндэслэсэн. Уг үндэслэсэн актыг нь шүүх илт хууль бус гэж хүчингүй болгосон атлаа түүнээс улбаатай гарсан захирамжийг хууль ёсны гэж үзсэн нь логик алдаатай, эрх зүйн хувьд зөрчилтэй” гэх гуравдагч этгээдийн гомдлын тухайд, тухайн захирамжийн улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй, уг захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр, магадлалд нэхэмжлэгчийн зүгээс гомдол гаргаагүй тул хяналтын шатны шүүхээс энэ талаар дүгнэлт өгөх шаардлагагүй юм.

32.Гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйн үүднээс, гуравдагч этгээд Г.Мөнхжаргал нь хуульд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр Дархан багийн Засаг даргын сонгуульд дахин нэр дэвших эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

33.Иймд, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхив.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 114/ШШ2025/0046 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 221/МА2026/0026 дугаар магадлалыг хэвээр үлдээж, гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар гуравдагч этгээдээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.



Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧИД

**М.БАТСУУРЬ
П.СОЁЛ-ЭРДЭНЭ
Ц.ЦОГТ
Г.БАНЗРАГЧ**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар: 001/ХТ2026/0036

Улаанбаатар
хот

**“Ти Ар Эс Жи” ХХК-ийн нэхэмжлэлтэй,
Сангийн яамны Худалдан авах ажиллагааны
улсын байцаагчид холбогдох
захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:	Г.Банзрагч
Танхимын тэргүүн:	Д.Мөнхтуяа
Шүүгчид:	М.Батсуурь
	Ц.Цогт
Илтгэгч шүүгч:	П.Соёл-Эрдэнэ
Нарийн бичгийн дарга:	Б.Энхжаргал

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
11 дүгээр сарын 24-ний өдрийн 128/ШШ2025/0857 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 01
дүгээр сарын 08-ны өдрийн 221/МА2026/0030 дугаар магадлалтай,

Хэргийн оролцогчид: Нэхэмжлэгчийн төлөөлөгч Н.Ундрах, түүний
өмгөөлөгч Г.Нацагдорж, хариуцагч Л.Амгалан нарыг оролцуулан,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт
шүүгчийн хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 113
дугаар хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг
арилгах”, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын
хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэсэн үндэслэлээр, нэхэмжлэгчийн
өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага: Сангийн яамны Худалдан авах
ажиллагааны улсын байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
17 дугаар дүгнэлтийг хүчингүй болгуулах,

2.Хэргийн нөхцөл байдал: “Ти Ар Эс Жи” ХХК нь “Эрдэнэт
үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Төрөл бүрийн шаваас, эмульс” нийлүүлэгчийг

сонгох тендер шалгаруулалтад оролцсон байх бөгөөд тухайн компанийг тендерт хавсаргаж ирүүлсэн “барааны шинжилгээний тайлангийн огноог өөрчилсөн” гэж үзэж, тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

3.Нэхэмжлэгчээс “... Шинжилгээний огноог өөрчлөөгүй, үйлдвэрлэгчээс ирсэн баримтыг ямар ч засваргүйгээр тендерт хавсаргаж өгсөн, QR кодын мэдээллийн зөрүү нь үйлдвэрлэгчийн асуудал бөгөөд нэхэмжлэгчтэй холбоогүй, дахин тендерт оролцох эрхийг хааж, компанийн үйл ажиллагаа, ажлаа чөлөөтэй сонгох эрхийг зөрчсөн” гэж,

4.Хариуцагчаас “... Тендерт хавсаргасан шинжилгээний тайлангийн огноо 2023 оны 09 дүгээр сарын 11, үйлдвэрлэгчийн QR кодоор гарч буй огноо 2023 оны 12 дугаар сарын 16, мөн QR кодоор харагдах мэдээлэл нь 2022 оны тайлан, эдгээр нь хоорондоо зөрүүтэй болох нь тогтоогдсон. Тендерт зөрүүтэй мэдээлэл ирүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ” гэж тус тус маргажээ.

5.Анхан шатны шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Үүнд:

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж зааснаас харвал тендер шалгаруулалтад оролцогч нь тухайн харилцаанд хариуцлагатай байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

5.2.Хариуцагч албан тушаалтан Z220725003 дугаар шинжилгээний бичиг нь 2023 оны 09 дүгээр сарын 11, QR кодыг уншуулан шалгахад 2022 оны 09 дүгээр сарын 11, захиалагчид үйлдвэрлэгчээс ирүүлсэн 2022 оны тайлангийн барааны QR кодыг уншуулан шалгахад 2022 оны 09 дүгээр сарын 11 буюу ижил огноотой, Z220725003 дугаар барааны 2023 оны шинжилгээний тайлангийн QR кодыг уншуулахад 2023 оны 12 дугаар сарын 16-ны огноотой байх бөгөөд энэ талаар нэхэмжлэгч маргаагүй.

5.3.Тендерт оролцогч байгууллага нь тодорхой шаардлагуудыг хангах ёстой бөгөөд санхүүгийн чадавх, техникийн нөхцөл баримт бичгүүд нь хуурамч, худал, эсхүл бодит бус мэдээлэл бүхий баримт бичгийг ирүүлэхгүй байх шаардлагатай бөгөөд тендерт оролцогч өөрийн хүргүүлсэн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцах учиртай.



5.4.Нэхэмжлэгч хуулийн этгээд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан тендерт хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгаагүй, мэдээлэл зөрүүтэй болох нь тогтоогдсон энэ тохиолдолд хариуцагч албан тушаалтан хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн маргаан бүхий захиргааны актыг хууль бус гэж үзэх үндэслэлгүй.

6.Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Үүнд:

6.1.Дээрх хууль болон журмын зохицуулалт нь тендерт оролцогч тендерт ирүүлсэн баримтыг үнэн зөв эсэхийг өөрөө хариуцах үүрэгтэй бөгөөд алдаатай тохиолдолд тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө залруулах боломжийг тендерт оролцогчид олгосон агуулгатай.

6.2.Тухайн тохиолдолд, нэхэмжлэгч “Ти Ар Эс Жи” ХХК-иас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Төрөл бүрийн шаваас, эмульс” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102303 дугаартай тендер шалгаруулалтад оролцохоор хүргүүлсэн тендерийн баримт бичигт хавсаргасан Z220725003 дугаартай барааны шинжилгээний тайлангийн огноо зөрүүтэй байгаа болох нь талуудын тайлбар, хэрэгт авагдсан баримтуудаар тус тус тогтоогдож байна.

6.3.Сангийн яамны Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар дүгнэлтээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1-д заасан бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендерт ирүүлсэн болохыг тогтоож, нэхэмжлэгч хуулийн этгээдийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх саналыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн нь хууль зөрчөөгүй.

7.Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.Хууль хэрэгжүүлэгч нь төрийн байгууллага, албан тушаалтан болохоос хувь этгээд биш. Тиймээс захиргаанд хүлээлгэсэн үүргийг тендер шалгаруулалтад оролцогчид халдаан, үүрэгтэй хэмээн дүгнэх буруу. Түүнчлэн зөвхөн өөрийнхөө өмнө буюу өөртөө л хариуцлага хүлээдэг

хувь этгээдийг хариуцлагатай байсангүй хэмээн буруутгаж байгаа нь хууль хэрэглээний алдаа болно.

7.2.Тендерийн баримт бичгийн ТШЗ-ийн 17.5-д шинжилгээний тайлан ирүүлэх шаардлага огт байгаагүй. Тэгэхээр шаардаагүй баримтад тулгуурлан дүгнэлт гаргасан нь буруу. Нэхэмжлэгч ямар нэгэн баримтыг өөрчлөөгүй, үйлдвэрлэгчээс ирүүлсэн баримтыг тэр чигт нь өгсөн байгаа.

7.3.“Хэбэй ханцай будаг” ХХК-ийн “Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ 2027 оны 03 дугаар сарын 08-ны өдөр хүртэл хүчинтэй” тухай баримт хэрэг дотор байгаа. Хүчинтэй байх хугацаа нь дуусчихсан байсан бол нэхэмжлэгч талд маргах боломж байхгүй. Өөрөөр хэлбэл 2022, 2023 гэсэн тоонд бус харин хүчинтэй байх хугацаанд шат шатны шүүхээс үндэслэл бүхий дүгнэлт хийсэнгүй.

7.4.Үйлдвэрлэгчээс өгсөн баримтыг захиалагчид өгсөн буюу огнооны зөрүү нь нэхэмжлэгчид хамаарахгүйг хүлээн зөвшөөрсөн баримтыг хуулийн шаардлага хангасан байдлаар шүүхэд гаргаж өгсөн ба түүнийг үнэлсэнгүй. QR код дээрх мэдээлэл 2022 он гэж гарах нь гэрчилгээ олгогч байгууллагын мэдээллийн системийн асуудал юм. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан тайлбарлахдаа “огноо зөрөх нь QR код анхны дээж өгсөн огноогоор үлдсэн байх”, “үйлдвэрлэгчийн баримт бичиг хүчин төгөлдөр” гэсэн.

7.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1-д заасан “баримт бичгийг өөрчлөх” үйлдэл хийгээгүй. Үйлдвэрлэгч өөрөө 2022 оны баримт өгсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн. QR кодын мэдээлэл өөрчлөгдөөгүй байж болно гэсэн. Үйлдвэрлэгч нь манай бичиг баримтыг засварлаагүй байна гээд байхад бичиг баримтыг өөрчилж, засварлалаа гэж байгаа нь хууль хэрэглээний алдаа болно. Иймд шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж өгнө үү.

ХЯНАВАЛ:

8.Анхан болон давж заалдах шатны шүүхээс нотлох баримтыг буруу үнэлж, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэснээс шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хангаж шийдвэрлэлээ.



9.Энэ хэргийн тухайд, хяналтын шатны шүүхээс хууль зүйн дүгнэлт өгөх шаардлагатай асуудал нь нэхэмжлэгч хуулийн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх санал гаргах хуулийн үндэслэл бүрдсэн эсэх байна.

10.Тогтоогдсон үйл баримтын тухайд, нэхэмжлэгч хуулийн этгээдийн тендерт ирүүлсэн Z220725003 дугаар бүхий шинжилгээний тайлангийн огноо нь 2023 оны 09 дүгээр сарын 11, захиалагчид үйлдвэрлэгчээс ирүүлсэн 2022 оны тайлангийн QR кодыг уншуулахад 2022 оны 09 дүгээр сарын 11 гэх огноотой, харин 2023 оны шинжилгээний тайлангийн QR кодыг уншуулахад 2023 оны 12 дугаар сарын 16-ны огноотой буюу хариуцагчаас “2022 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр дүгнэгдсэн шинжилгээний тайланг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр гэж өөрчилсөн” гэж үзэж, нэхэмжлэгчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэсэн байна.

11.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6.1-д “энэ хуулийн 56.5-д заасан тохиолдолд оролцогчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх санал гаргах” гэж, 56.5.1-д “худалдан авах ажиллагаанд оролцоход оролцогчийн ерөнхий болон чадавхын шаардлага, туршлагыг хангах талаар хуурамч баримт бичиг эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендер ирүүлсэн” гэж заасныг агуулгаар нь тайлбарлахад, тендерт оролцогч тендерт ялах, өөртөө давуу байдал бий болгох зорилгоор санаатайгаар, зөрчлийн субьектив талын шинжийг хангаж, хуурамч баримт бичиг бүрдүүлж ирүүлсэн, эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилсөн идэвхтэй үйлдэл гаргасан бол дахин тендерт оролцох эрхээ хязгаарлуулах үр дагавар үүснэ.

12.Энэ тохиолдолд нэхэмжлэгч хуулийн этгээд нь шинжилгээний баримт бичгийг өөрчилсөн санаатай үйлдэл тогтоогдоогүй, шинжилгээний тайлангийн QR кодыг уншуулахад огноо өөр байх нь нэхэмжлэгчийг буруутгах, хуулийн дээрх урьдчилсан нөхцөлд заасан “бусад этгээдийн баримт бичгийг өөрчилсөн” гэх үндэслэлд хамаарахгүй, “зөрүүтэй баримт өгсөн”-д тооцох үндэслэл болох ба энэ талаар анхан болон давж заалдах шатны шүүхээс буруу дүгнэлт хийжээ.

13.Тодруулбал, үйлдвэрлэгчээс ирүүлсэн шинжилгээний тайлангийн “огноо зөрүүтэй байгаа” нөхцөл байдал нь тухайн тендерт оролцогч этгээдийг тендерт хуурамч баримт бичиг өгсөн эсхүл бусад этгээдийн баримтыг санаатайгаар өөрчилж ирүүлсэн “зөрчил үйлдсэн” гэж дүгнэх, улмаар дараа дараагийн тендерт оролцох эрхийг хязгаарлах хууль зүйн үндэслэл болохгүй, харин уг баримтын зөрүүг тодруулах, учир

шалтгааныг олох, холбогдох эх сурвалжаас нягтлах, бусад баримттай харьцуулан тендерийг үнэлэх үр дагавар үүсгэхээр байна.

14.Иймээс нэхэмжлэгчийн “дахин тендерт оролцох эрхийг хааж, компанийн үйл ажиллагаа, ажлаа чөлөөтэй сонгох эрхийг зөрчсөн” гэх гомдлыг хангах үндэслэлтэй.

15.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Оролцогч тендерт холбогдох баримт бичиг болон ирүүлсэн мэдэгдлийн үнэн зөвийг хариуцна” гэж зааснаар тендерт оролцогч нь тендерт оролцохдоо өөрийн гаргаж өгсөн баримт бичгийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцах зарчимтай, энэ маргааны тухайд нэхэмжлэгчээс шинжилгээний тайлангийн QR кодыг уншуулж, огноо таарч байгаа эсэхийг нягтлан шалгаагүй, зөрүүтэй баримт өгснийг тендерт ялах зорилготой хууран мэхэлсэн санаатай үйлдэлд тооцохгүй, мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1-д заасан тендерт оролцогчийн аливаа тендерт оролцох эрхийг хязгаарлах шууд үндэслэл болохгүй, харин зөрүүтэй баримт ирүүлсэнд тооцох, оролцсон тендертээ шалгарахгүй байх, үнэлгээнд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгэж болно.

16.Хариуцагчаас нэхэмжлэгч хуулийн этгээдийг “2022 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр дүгнэгдсэн шинжилгээний тайланг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр болгож өөрчилсөн” гэж буруутгахдаа үндэслэлээ тодорхой тайлбарлаагүй, нотлоогүй, 2022 он болон 2023 оны шинжилгээний тайлан тус бүрийг ялгаж зааглан ойлгомжтой тайлбарлаагүй, 2022 он зөрчилтэй бол 2023 он зөрчилгүй байгаад, тухайн барааны хүчинтэй хугацаа дуусаагүй байгаа зэрэгт дүгнэлт хийгээгүй, хэрэгт “үйлдвэрлэгч “Хэбэй ханцай будаг” ХХК-иас тус бараанд шинжилгээ хийлгэсэн 2022, 2023 онуудын тайланг ирүүлсэн. “Десерт мийт” ХХК нь 2022 оны тайланг 2023 он болгож засварласан байна” гэх баримт¹ авагдсан байх боловч нотлох баримтын шаардлага хангаагүй, ямар байгууллагаас гаргасан болох, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэг байхгүй, баталгаат орчуулгаар орчуулагдаагүй, харин үйлдвэрлэгчээс “JL-029-02-05 тоот хяналтын дугаартай тус шинжилгээний хуудасны QR код нь 2022 оных хэвээр байгаа боловч дараагийн дээж илгээсэн огноо 2023 оноор бүртгэгдсэн байна, ... тухайн үед магадгүй анхны QR кодыг өөрчлөлгүй, зөвхөн дээж илгээсэн огноог шинэчилсэн байна, манай компани энэхүү шинжилгээний тайлангийн үнэн бодит хүчинтэй болохыг баталгаажуулж байна” гэсэн агуулгатай² баримт ирүүлжээ.

¹ Хавтаст хэргийн 55 дугаар тал

² Хавтаст хэргийн 68 дугаар тал



17.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Захиалагч оролцогчоос бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод нийцэх, эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах эсэхийг тогтоох шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, эсхүл холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно” гэж зааснаар техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг нотлох баримтууд хооронд зөрсөн тохиолдолд хариуцагчаас холбогдох этгээдээс тодруулах ажиллагаа хийж, баримт бичгийн зөрүүг арилгаж, үндэслэл бүхий дүгнэлт гаргах, гаргасан шийдвэрийн үндэслэлээ нотлох үүрэгтэй, энэ үүргээ хариуцагчаас биелүүлээгүй байх тул нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэв.

18.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга журмын тухайд, Сангийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 145 дугаар тушаалаар нэхэмжлэгч хуулийн этгээдийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн байх бөгөөд уг тушаалын үндэслэл болсон маргаан бүхий улсын байцаагчийн дүгнэлт хүчингүй болсон тул нэхэмжлэгч хуулийн этгээдийг эрхээ тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлээс хасах замаар шүүхийн шийдвэрийг биелүүлнэ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 128/ШШ2025/0857 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 221/МА2026/0030 дугаар магадлалыг хүчингүй болгож, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1, 56.6.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Ти Ар Эс Жи” ХХК-ийн нэхэмжлэлийг хангаж, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар дүгнэлтийг хүчингүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

**М.БАТСУУРЬ
Ц.ЦОГТ
П.СОЁЛ-ЭРДЭНЭ**



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003

